



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

“Улаансан” ХК-ийн нэмж гаргасан хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Увс аймаг дахь сум дундын шүүхийн 2011 оны 359 дугаар шийдвэр, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2011 оны 488 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Улаансан” ХК-ийн 1999 онд нэмж гаргасан 304 /гурван зуун дөрөв/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 24871 /хорин дөрвөн мянга найман зуун далан нэг/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасч, тус хувьцаат компанийн гаргасан нийт хувьцааг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 62177 /жаран хоёр мянга нэг зуун далан долоо/ ширхэгээр тогтоосугай.

2. Тогтоолын 1 дэх заалтын дагуу 304 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 24871 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Иргэн Ж.Амаржаргалын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс дахь “Улаансан” ХК-ийн 24871 ширхэг энгийн хувьцааны үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгохыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу өөрчлөлтийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ирүүлэхийг “Улаансан” ХК /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

000011

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН